



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 4/08

Чингис хот

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.3, 19, 20 дугаар зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10-р зүйлийн 10.4.4 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 266 тогтоолын 2 дугаар хавсралт, Улсын онцгой комиссын даргын 2023 оны 02 тушаалын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сариг дөрөвдүгээр багт гахайн африкийн мялзан өвчин улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн шинжилгээгээр оношлогдсон тул 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаанд хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2.Голомтын болон сэжигтэй, хамгаалалтын бүсийн айл өрхийн байршлыг тогтоож зураглал гарган тандалт судалгаа, эрүүл мэндийн үзлэг хийж, халдваргүйтгэлийн ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт даалгасугай.

3.Уг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг гахайн аж ахуйн эрхэлж байгаа иргэдэд цаг алдалгүй хүргэж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай

4.Хоол үйлдвэрлэлийн салбарт гахайн махыг үйл ажиллагаанд нэвтрүүлж буй ресторан зоогийн газруудад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахыг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (Д.Сандагдорж)-д үүрэг болгосугай

5.Уг өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчинтэй тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг тухай бүрт өгч ажиллахыг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын нярав (Л.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

6.Голомтын бүсэд ажиллах хүн хүч техник хэрэгсэл, Устгалын ажлыг чанартай зохион байгуулахыг Өндөрхаан хот тохижилт ОНӨААТҮ газрын дарга (Э.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

7.Мал амьтан, машин техникийн хөдөлгөөнд холбогдох журмын хүрээнд хяналт тавьж хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан гарах санхүүгийн зардлын тооцоог гарган танилцуулж зарцуулахыг Шуурхай штабын дарга (Г.Лхагвабаатар)-д даалгасугай.

8.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын онцгой комиссын орлогч дарга (А.Боргил)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭРДЭНЭБААТАР